



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Барилга, байгууламжийн талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд ашиглалтад ороогүй, гүйцэтгэл нь удаашралтай байгаа, үйл ажиллагаа нь зогссон барилга, байгууламжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад дурдсан зарим барилга, байгууламжуудаас “Нийслэл өргөө” ХХК-ийн Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт барих 300 ортой төрөх эмнэлгийн, “Арвис интернэшнл” ХХК-ийн 60 ортой Геронтлогийн үндэсний төвийн барилгын, Чингэлтэй дүүрэгт барих 1000 суудал бүхий “Дүүргийн спорт цогцолбор”, “Гуулин тал” ХХК-ийн Говь-Алтай аймгийн Цээл суманд барих Эрүүл мэндийн төвийн 10 ортой эмнэлгийн барилга, байгууламж, хөрөнгийг тус тус хүлээн авах Ажлын хэсгийг байгуулан, ажиллуулж, дүнг 2015 оны 3 дугаар сарын 01-ны дотор танилцуулахыг Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хүлээн авах шаардлага бүхий барилга, байгууламж, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах зорилгоор харуул хамгаалалтыг шуурхай зохион байгуулж, ажиллуулахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т үүрэг болгосугай.
4. Хугацаандаа дуусаагүй, гүйцэтгэл нь удааширсан, шүүх, хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа, шүүхээр шийдвэрлэгдсэн болон цаашид үйл ажиллагаа нь зогссон барилга, барилгын угсралтын ажлыг гүйцэтгэгч компани, хуулийн этгээдүүдтэй байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-г цуцлах, холбогдох хохирлыг нэхэмжлэх ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/ нарт үүрэг болгосугай.
5. Дуусаагүй барилга, байгууламж, түүний холбогдох хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн салбарын хөрөнгийн бүртгэлд тусгаж, блансад

080192


авахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Г.Баярсайхан/-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД




Г.ШИЙЛЭГДАМБА



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 17 өдрийн  
60 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД АШИГЛАЛТАД ОРООГУЙ, ГҮЙЦЭТГЭЛ НЬ УДААШРАЛТАЙ  
БАЙГАА, ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ЗОГССОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Гүйцэтгэгч аж ахуй нэгж	Барилгын байршил	Төсөвт өртөг	Барилгын, барилга угсралтын ажлын гүйцэтгэл /хувиар/	Санхүүжилтийн дүн	Тайлбар
1	"Нийслэл өргөө" ХК	Төрөх эмнэлэг, 300 орт /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг/	19000,0	68%	15746,1	Барилгын барилга угсралтын ажилд нэмэлт санхүүжилт шаардлагатай гэх шалтгаанаар 2013 оны 08 дугаар сараас барилга угсралтын ажлыг зогсоосон.
2	"Арвис интернэшнл" ХХК	Грентлогийн төв, 60 орт/Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг/	4724,6	48%	2722,0	Санхүүжилт нь хүрэхгүй шалтгаанаар барилгын барилга угсралтын ажил зогссон.
3	"Жи-жи-ай" ХХК	Төрөх эмнэлгийн барилга, 50 орт, /Сүхбаатар аймаг/	3276,3	80%	2530,2	2015 оны Улсын төсөвт санхүүжилт батлагдаагүй.
4	"Гуулин тал" ХХК	Эмнэлгийн барилга, 10 орт/Говь-Алтай аймаг, Цээл сум/	535,0	40%	469,8	Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа хэтрүүлсэн. Санхүүжилтээ бүрэн авсан.
5	"Монинжбар" ХХК	50 ортой төрөх эмнэлгийн барилга /Дундговь аймаг, Сайншанд сум/	1817,9	60%	1285,0	2014, 2015 оны Улсын төсөвт санхүүжилт нь батлагдаагүй ч ажил гүйцэтгэх гэрээний хугацаа хэтрүүлсэн.



6	"Бэржин-Уньт" ХХК	Эмнэлгийн барилга /Дундговь аймаг, Дэлгэрхангай сум/	500,0	40%	200,0	2014, 2015 оны Улсын төсөвт санхүүжилт нь батлагдаагүй ч ажил гүйцэтгэх гэрээний хугацаа хэтрүүлсэн.
7	"Хөх тэнгэр Хөвсгөл" ХХК	Сумын эрүүл мэндийн төв, 20 орт, /Хөвсгөл аймаг, Их-Уул сум/	850,0	40%	339,2	2014 оны 08 дугаар сарын 14-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээг нь байгуулан ажлыг нь эхлүүлсэн боловч 2015 оны улсын төсөвт санхүүжилт нь батлагдаагүй.
8	"Мөн хурд" ХХК	Спорт цогцолбор, усан бассейн барилга/Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	9902,0	10%	638,0	2015 оны Улсын төсөвт санхүүжилт батлагдаагүй.